



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/55/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Аккурэйт Финанс Аудит ХХК
Захирал: Ж.Оюунбилэг
Утас: 70133743 Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Албан шаардлага	15
8.2 Зөвлөмж.....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НББОС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ЭМНДШ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/591

танай _____-ны № _____-Т

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ
ТӨВ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Н.ГАНБОЛД ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант оны нийт орлогыг 5,294.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,119.8 сая төгрөгөөр, 157.2 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 704.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 1,214.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,151.8 сая төгрөгийн зардал гарган, 935.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд геологи судалгааны ажлын хүрээнд 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс ковид цар тахлын улмаас өрөмдлөгийн ажил цуцалснаас 22.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Gazar - 77.Docx

001050940

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,545,541,811.39	1,119,861,724.05
1.1.2	Дансны авлага	58,773,000.00	8,034,048.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	253,393.98	834,846.18
1.1.4	Бусад авлага	291,596,287.00	173,620,005.00
1.1.6	Бараа материал	12,839,236.40	49,854,285.68
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,909,003,728.77	1,352,204,908.91
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	891,686,034.39	1,308,197,416.34
1.2.2	Биет бус хөрөнгө	174,783,800.00	233,683,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,066,469,834.39	1,541,881,216.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,975,473,563.16	2,894,086,125.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	107,938,300.00	
2.1.1.3	Татварын өр	15,840,621.94	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	159,572,560.00	159,532,800.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	283,351,481.94	159,532,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	283,351,481.94	159,532,800.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	979,226,789.06	979,226,789.06
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	154,598,986.59	154,598,986.59
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	39,589,627.18	39,589,627.18
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,518,706,678.39	1,561,137,922.42
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,692,122,081.22	2,734,553,325.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,975,473,563.16	2,894,086,125.25

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,962,305,863.72	1,213,991,887.27
2	Борлуулалтын өртөг	4,232,628,730.54	1,737,459,058.16
3	Нийт ашиг(алдагдал)	729,677,133.18	(523,467,170.89)
5	Хүүгийн орлого	51,880,698.10	21,766.51
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(493,464,696.63)	(393,542,196.62)
12	Бусад зардал	(53,329,861.20)	(18,317,396.91)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	18,489,307.25	(512.41)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	253,252,580.70	(935,305,510.32)
19	Орлогын татварын зардал	30,641,888.01	2,176.65
20	Татварын дараах ашиг (алдагдал)	222,610,692.69	(935,307,686.97)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	222,610,692.69	(935,307,686.97)
24	Орлогын нийт дүн	222,610,692.69	(935,307,686.97)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	2,671,535,743.70	3,844,951,146.53
Залруулсан үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	2,671,535,743.70	3,844,951,146.53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	222,610,692.69	222,610,692.69
Зарласан ногдол ашиг	-	-	-	(375,439,758.00)	(375,439,758.00)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	2,158,706,678.39	3,692,122,081.22
Залруулсан үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	2,158,706,678.39	3,692,122,081.22
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(935,307,686.97)	(935,307,686.97)
Зарласан ногдол ашиг				(22,261,069.00)	(22,261,069.00)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	1,561,137,922.42	2,734,553,325.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,338,112,437.00	1,594,206,383.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,324,625,190.00	1,315,320,598.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	13,487,247.00	22,271,503.00
	Бусад мөнгөн орлого	-	256,614,282.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,298,909,411.08	2,358,166,895.44
	Ажиллагчдад төлсөн	1,796,512,720.71	1,239,681,432.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	499,383,370.03	336,263,223.49
	Бараа материал худалдан авахад төлсөн	205,875,727.00	63,022,813.00
	Ашиглалтын зардалд төлсөн	73,983,672.91	46,205,881.36
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	187,773,733.00	92,338,400.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	783,453,236.51	229,572,569.97
	Даатгалын төлбөрт төлсөн	2,521,368.00	2,292,840.00
	Бусад мөнгөн зарлага	1,749,405,582.92	348,789,735.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	39,203,025.92	(763.960.512.44)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,880,698.10	21,766.51
	Хүлээн авсан хүүний орлого	51,880,698.10	21,766.51
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	489,048,370.00	639,440,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	489,048,370.00	580,540,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	58,900,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(437,167,671.90)	(639,418,233.49)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	375,439,758.00	22,301,341.41
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Төлсөн ногдол ашиг	375,439,758.00	22,261,069.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(375,439,758.00)	(22,301,341.41)
4	Валютын ханшийн зөрүү	24,984,739.99	(40,272.41)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(748,419,663.99)	(1,425,680,087.34)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,293,961,475.38	2,545,541,811.39
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,545,541,811.39	1,119,861,724.05

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	мян.төг	5,033,946.6	5,294,542.2	1,213,991.9	4,080,550.3	22.9
2	Геологи хайгуулын ажил	мян.төг	4,872,755.9	4,385,451.3	1,213,351.0	3,172,100.3	27.7
3	Өрөмдлөгийн ажил	мян.төг	-	909,090.9	-	909,090.9	-
4	Бусад орлого	мян.төг	161,190.7	-	640.9	(640.9)	-
5	Нийт зардал	мян.төг	4,780,694.0	5,119,830.1	2,151,818.7	2,968,011.4	42.0
6	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	546,794.6	611,687.7	411,883.8	199,803.9	67.3
7	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	253,252.6	174,712.1	(935,305.5)	1,110,017.6	(535.3)
8	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	222,610.7	157,240.9	(935,305.6)	1,092,546.5	(594.8)
9	Төсөвт төлөх татвар, шимтгэл	мян.төг	1,576,893.7	1,219,570.3	605,213.3	514,357.0	49.6
10	ААНОАТатвар	мян.төг	30,641.9	17,471.2	12,575.6	4,895.6	72.0
11	НӨАТатвар	мян.төг	481,978.9	529,454.2	124,919.0	404,535.2	23.6
12	ХХОАТатвар	мян.төг	183,720.5	160,500.6	106,679.9	53,820.7	66.5
13	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	2,676.3	8,129.5	2,514.5	5,615.0	30.9
14	ЭМНД-ын шимтгэл	мян.төг	502,436.3	484,606.9	336,263.2	148,343.2	69.4
15	Ноогдол ашиг	мян.төг	375,439.8	19,407.9	22,261.1	(2,853.2)	114.7
16	Хөрөнгө оруулалт	мян.төг	494,185.4	704,800.0	654,440.0	50,360.0	92.9
17	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.95	0.97	1.77	(0.80)	-
18	Нийт авлага	мян.төг	350,622.7	466,596.3	182,488.8	284,107.5	39.1
19	Нийт өглөг	мян.төг	283,351.5	168,000.0	159,532.8	8,467.2	94.9
20	Нийт ажиллагсдын тоо	хүн	130	125	84	41	67.2
21	Цалингийн сан	мян.төг	2,002,215.7	1,905,309.7	1,296,149.0	609,161.7	68.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Аккурэйт финанс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Я.Золзаяа, аудиторын туслах А.Алтанчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтыг захирал Ж.Оюунбилэг, чанарын хяналтын менежер Л.Гоёцэцэг нар хэрэгжүүлсэн.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын-дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Аудитыг төлөвлөх үе шатанд материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,779.4 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 47.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Геологи, геофизик, геохими, гидрогеологийн региональ судалгаа,
- Тандан судалгаа, эрлийн ажлыг мөрдөж буй аргачлалын дагуу гүйцэтгэх,
- Лабораторийн зарим шинжилгээг стандарт зааврын дагуу гүйцэтгэх,
- Цооног өрөмдөх, сэргээн засварлах, тоноглох.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. 100 хувь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Геологи эрдэс баялгийн яамны 1993 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 09 дүгээр тушаалаар Геологийн судалгааны төв ТӨҮГ-ыг үүсгэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд Монгол орны нутаг болон гадаад улсын нутаг дэвсгэрт региональ, бүс нутгийн геологийн бүх төрлийн ашигт малтмалын иж бүрэн судалгаа хийх чиглэлээр олон улсын жишигт хүрсэн засаглал, технологи, чадавх бүхий үйлдвэрийн газар болох, Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хувь хүн, хуулийн этгээдийн захиалгаар геологийн судалгааны ажил гүйцэтгэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжихээр ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 41-ээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ТӨБЗГ-аас тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,545,541.8	1,119,861.7	(1,425,680.1)
Авлага	350,622.7	182,488.9	(168,133.8)
Бараа материал	12,839.2	49,854.3	37,015.1
Үндсэн хөрөнгө	891,686.0	1,308,197.4	416,511.4
Биет бус хөрөнгө	174,783.8	233,683.8	58,900.0
Нийт хөрөнгийн дүн	3,975,473.5	2,894,086.1	(1,081,387.4)
Өр төлбөрийн дүн	107,938.3	-	(107,938.3)
Богино хугацаат өглөг	15,840.6	-	(15,840.6)
Урьдчилж орсон орлого	159,572.6	159,532.8	(39.8)
Эздийн өмч	3,692,122.0	2,734,553.3	(957,568.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,975,473.5	2,894,086.1	(1,081,387.4)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 1.1 сая төгрөг болж 1.4 сая төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахлын улмаас өрөмдлөгийн ажил цуцлагдаж, төлөвлөсөн борлуулалтын орлого буурсанаас шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэл 182.5 сая төгрөг болж буурсан нь тайлант онд төслийн гүйцэтгэлийн баталгааны хүрээнд үүссэн авах 118.0 сая төгрөгийн авлага төлөгдсөн нь голлон нөлөөлжээ. Авлага дансны үлдэгдэлд татварын авлага 8.0 сая төгрөг, төслийн гүйцэтгэлийн баталгааны авлага 173.6 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 49.8 сая төгрөг болж 37.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан 212.3 сая төгрөгийн бараа материал зарцуулагдаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 416.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр 580.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл худалдан авсан нь хөрөнгийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна. ТӨБЗГ-ын 2020 оны 75 дугаар тогтоолоор нийт 8.2 сая төгрөгийн өртөгтэй, 10 ширхэг хөрөнгө, 2021 оны 70 дугаар тогтоолоор 5.7 сая төгрөгийн өртөгтэй ачааны машиныг акталж бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 58.9 сая төгрөгөөр өссөн нь компьютерын программ хангамж шинээр худалдан авч бүртгэснээс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг аккруэл суурьт үндэслэн холбогдох

зардлын данснүүдэд хуримтлуулан бүртгэж, ажил гүйлгээг гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан үйл үйлчилгээний өртөг, үйл ажиллагааны зардал, бусад зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 99.9 сая төгрөгөөр буурсан нь Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалтад тэнцэх нөхцөл бүрдээгүйгээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан үйлчилгээний өртөгт Торлог уул-50, Овоот толгой-50, Геомэдээллийн сан-2019 болон бусад төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гарсан цалин, НДШ, сэлбэг, засвар үйлчилгээ, түрээс, томилолт, элэгдэл, шатахуун, бараа материалын гэх мэт зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Геологийн судалгааны төв нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 635 дугаар тогтоолоор Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5,294.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,119.8 сая төгрөгөөр, 157.2 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 704.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна. ТӨБЗГ-ын 2021 оны А-1/354 дугаар албан бичгийн хавсралтаар Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 5,294.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,570.2 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 1,214.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,151.8 сая төгрөгийн зардал гарган, 935.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,214.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 4,080.6 сая төгрөг буюу 77.1 хувиар тасарсан нь Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх нийт геологи хайгуулын зөвлөх үйлчилгээний 9 багц тендерт оролцсоноос төсөөлж байсан төсөл, хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалтад захиалагчтай нэгдмэл сонирхолтойн улмаас тэнцэх нөхцөл бүрдээгүй - байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,151.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,968.0 сая төгрөгөөр бага буюу 42.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлого тасалдсан нь голлон шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу геологи хайгуул, өрөмдлөгийн ажилд өөрийн эх үүсвэрээс 513.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 935.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,092.5 сая төгрөгөөр дутуу байгаа нь зорилтот түвшний орлого тасалдсанаас шалтгаалжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А-1/1106 тоот шийдвэрийн дагуу тайлант онд 22.2 сая төгрөгийн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан оруулбал зохих мэдээллүүдийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Геологийн судалгааны төв ТӨҮГ нь тайлант онд нийт 3,570.4 сая төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар илэрсэн 14.7 сая төгрөгийн алдаа зөрчилд залруулах 3 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад алдаа зөрчлийг залруулаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгалаа.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 40.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	40,020.0	3	40,020.0	-	-	100.0
Нийт дүн	3	40,020.0	3	40,020.0	-	-	100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх, орон тоо, цалин хөлс, хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ, томилолтын зардал гэх мэт төсвийн хөрөнгө, цалингийн санг хэмнэж ажиллаж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 19.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 28.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 47.8 сая төгрөгийн түвшинээс 19.4 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Албан шаардлага

1. Тайлант онд худалдан авалт, бараа материалтай холбоотой төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 9.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг: 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр бус, бүрдэл дутуу баримтаар, эсхүл анхан шатны цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх,

2. Тайлант оны батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогын төлөвлөгөө биелэгдээгүйгээс алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийг үр ашигтай төлөвлөх, судалгаа тооцоог үндэслэлтэй гаргах, зөрчлийг давтан гаргахгүй байх,

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

СТ/2021-Б-02 тоот гэрээгээр худалдан авсан 9.9 сая төгрөгийн ном наах машин, үндсэн хөрөнгийн шинж чанартай 8.5 сая төгрөгийн бусад хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллаагүй санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн, бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг зөв ангилан бүртгэж, бараа материалын дансанд бүртгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх,

2. Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

НӨАТ-ын 2021 оны 6 дугаар сарын тайланд худалдан авалтын дүнг 0,7 сая төгрөгөөр алдаатай тайлагнасан байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 16 зүйл.Албан татвар ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, тайлагнах 16.1.Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор ... баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана” гэсэн заалт, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй, санхүүгийн тайлан баланс үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тайланг цаг тухай бүр хуулийн хугацаанд илгээн, баталгаажсан эсэхийг шалган ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Геологийн судалгааны төв	АХГ-2022/55/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 18.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	Хөрөнгийг зөв ангилан бүртгэж, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх,	1	18,237.0									1	18,237.0
2	Геологийн судалгааны төв	АХГ-2022/55/НА-СТА-ТӨА	Анхан шатны баримтын бүрдэл дутуу харилцагч байгууллагуудаас цахим И баримт гаргуулан аваагүй байна.	Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх,	1	9,140.3					1	9,140.3				
3	Геологийн судалгааны төв	АХГ-2022/55/НА-СТА-ТӨА	2021 оны 6 дугаар сарын НӨАТ-ын тайланг худалдан авалтын дүнг алдаатай тайлагнасан байна.	НӨАТ-ын тайланг цаг тухай бүр хуулийн хугацаанд илгээн, баталгаажсан эсэхийг шалгаж байх,	1	749.2									1	749.2
4	Геологийн судалгааны төв	АХГ-2022/55/НА-СТА-ТӨА	Тайлант онд зорилтод түвшин, орлогын төлөвлөгөө тасалдаж алдагдалтай ажилсан.	Төсвийг үр ашигтай төлөвлөх, судалгаа тооцоог үндэслэлтэй гаргах,	1	-					1					
ДҮН					4	28,396.5	-	-	-	-	2	9,140.3	-	-	1	19,256.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 496/АО150053
АХГ-2022/55/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргаж, тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 9,140,300.00 төгрөгийн худалдан авалтын цахим И баримт гаргуулан аваагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, ... мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгэх," Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 495 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтыг и-баримтын системд баталгаажуулах, зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгааны төвийн захирал Н.Ганболд, ерөнхий нягтлан бодогч Т.Батбилэг нарт хариуцуулав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.ОЮУНБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

9019120396

\\10.10.10.201\audit\АХГ\Албан Шаардлага\2022\0315 Auditin 2 Газар-193.Docx

0001081356



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 494/АХГ-2022/55/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны нийт орлогыг 5,294,542,200.00 төгрөгөөр, нийт зардлыг 5,119,830,100.00 төгрөгөөр, 157,240,900.00 төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 1,213,991,900.00 төгрөгийн орлого бүрдүүлж, 2,151,818,700.00 төгрөгийн зардал гарган, 935,305,600.00 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө бодовсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай төлөвлөх, ашигтай ажиллахад анхаарч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгааны төвийн захирал Н.Ганболд, ерөнхий нягтлан бодогч Т.Батбилэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-194.Docx

0001081354

ТЭМДЭГЛЭЛ

A series of 28 horizontal dotted lines for writing a conclusion.